



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар ХЭТ  
1566


Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
С.ЭРДЭНЭ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүхийн шийдвэрийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгжид 25,711 сая төгрөгийн нөхөн төлбөр олгох зардлыг тусгасан талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ЭРДЭНЭЭС ЕРӨНХИЙ САЙД  
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**АСУУЛТ 1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлөх 25 тэрбум 711 сая төгрөгийг яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад хуваарилсан талаар:**

**ХАРИУЛТ:** Хууль зүй, дотоод хэргийн сайдын жил бүрийн төсвийн багцад Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.1, 498.2, 498.4, Захиргааны ерөнхий хуулийн 101.1, 101.2-т тус тус зааснаар хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн бусдад учруулсан хохирлыг төр хариуцах нөхөн төлбөрийн зардлыг тусган зохих хэмжээгээр шийдвэрлэж байна.

Өмнөх жилүүдэд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуйн нэгжид олгох нөхөн төлбөрийн зардлыг олговол зохих хэмжээнээс нь бууруулан баталж байснаас шалтгаалан төлбөр авагчид олговол зохих 25.7 орчим тэрбум төгрөг хуримтлагдан түүнийг төсвийн тодотголд тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 1-1/3154 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Үүнээс, урсгал зардлын шинжтэй нийт 8,817.8 сая төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардалд тусган олгохоор тооцсон. Үлдэх хэсэг болох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний улмаас үүссэн хохирлын нөхөн төлбөрийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын хөрөнгийн зардалд тусгасан болно.

Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас шүүхийн шийдвэрийн дагуу иргэд, аж ахуйн нэгжид олгох нөхөн төлбөрийн зардлыг урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд тусгасан мэдээллийг доорх байдлаар танилцуулж байна.

**Урсгал зардалд тусгасан талаар:**

Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төрөөс хариуцах нөхөн төлбөрийн зардлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багц дахь Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны нөхөн төлбөрийн зардалд жил бүр төсөвлөж байна. Ажлаас үндэслэлгүй халсан талаар албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэр, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад болон ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авах ажиллагааны гэрээний үүрэг биелэгдээгүй зэрэг шалтгааны улмаас хохирсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ирсэн шийдвэр гүйцэтгэх хуудсыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар хохирлыг олгож ирсэн.

Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын төсөлд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны нөхөн төлбөрийн зардалд зориулж Хууль зүй, дотоод

хэргийн сайдын төсвийн багцад 8,817.8 сая төгрөг тусгагдсан. Уг нөхөн төлбөрт төсөвлөсөн нийт хөрөнгийн 14.5 хувь буюу 1,282.2 сая төгрөгийг ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас олгох хохирлын нөхөн төлбөрт, 49.5 хувь буюу 4,365.9 сая төгрөгийг төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад алдаа гаргасны улмаас бусдад учруулсан хохирлын нөхөн төлбөрт, 32.3 хувь буюу 2,844.4 сая төгрөгийг гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас бусдад бий болгосон хохиролд, 3.3 хувь буюу 293.8 сая төгрөгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учруулсан хохиролд, 0.4 хувь буюу 31.6 сая төгрөгийг хууль, тогтоомжийн дагуу олгох ёстой байснаас олгогдоогүй тэтгэмжийн зардалд тус тус тусгасан болно.

Нийт хохирогч буюу төлбөр авагчийн 30.4 хувийг иргэд, 60.4 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, 9.2 хувийг төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, хоршоо зэрэг бусад байгууллагууд эзэлж байна.

### Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс олгох төлбөр-урсгал зардал /сая төгрөгөөр/

№	Шалтгаан	Олгох төлбөр	Эзлэх хувь	Төлбөр хүлээн авагч этгээд		
				Иргэд	Компани	Бусад
<b>НИЙТ ДҮН</b>		<b>8,817.8</b>	<b>100%</b>	<b>2,679.5</b>	<b>5,323.1</b>	<b>815.2</b>
1.	Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас олгох хохирлын нөхөн төлбөр	1,282.2	14.5%	1,281.9	-	0.3
2.	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд алдаа гаргасны улмаас бусдад учруулсан хохирол	4,365.8	49.5%	405.7	3,931.8	28.3
3.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учруулсан хохирол	293.8	3.3%	293.8	-	-
4.	Хууль тогтоомжийн дагуу олгох ёстой байснаас олгогдоогүй тэтгэмж, зардал	31.6	0.4%	31.6	-	-
5.	Гэрээний үүрэг биелүүлээгүйгээс бий болсон хохирол	2,844.4	32.3%	666.5	1,391.3	786.6
<b>Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо</b>		<b>277</b>		<b>214</b>	<b>45</b>	<b>18</b>

## **Хөрөнгийн зардалд тусгагдсан талаар:**

Засгийн газрын дотоод өр төлбөрийг барагдуулах нэг удаагийн арга хэмжээний хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагад шүүхийн шийдвэрийн дагуу төлөх төлбөрт Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгийн зардалд 16,894.1 сая төгрөгийг тусгасан. Үүнээс гадна Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдээгүй боловч бусад төсвийн ерөнхийлөн захирагч хариуцахаар шийдвэрлэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой шүүхийн шийдвэрүүдийг үндэслэн нэмж тусгасан. Ингэснээр шүүхийн шийдвэрийн дагуу барагдуулах хөрөнгө оруулалтын шинжтэй нийт зардал 32,893.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд дараахь 12 төлбөр хамаарч байна. Үүнд:

1. 2012 оны Монголын Үндэсний арбитрын 47 дугаар шийдвэрээр Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас 878.3 сая төгрөг;
2. 2015 оны Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 84 дүгээр шийдвэрээр Зам тээврийн яамнаас 144.2 сая төгрөг;
3. 2015 оны Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 820 дугаар шийдвэрээр Зам, тээврийн яамнаас 394.9 сая төгрөг;
4. 2016 оны Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/шш2016/01933 тоот шийдвэрээр Зам тээврийн яамнаас 4,265.7 сая төгрөг;
5. 2016 оны Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/шш2016/01375 болон 101/шш2016/02639 тоот шийдвэрээр Зам, тээврийн яамнаас 4,275.7 сая төгрөг;
6. 2016 оны Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/шш2016/02720 тоот шийдвэрээр Зам тээврийн яамнаас 2,391.0 сая төгрөг;
7. 2016 оны Монголын Үндэсний арбитрын 173 дугаар шийдвэрээр Зам, тээврийн яамнаас 7,867.2 сая төгрөг;
8. 2016 оны Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182/шш2016/00955 тоот шийдвэрээр Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамнаас 2,848.2 сая төгрөг;
9. 2016 оны Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/шш2016/02273 тоот шийдвэрээр Эрүүл мэндийн яамнаас 57.1 сая төгрөг;
10. 2016 оны Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 669 дугаар шийдвэрээр Эрүүл мэндийн яамнаас 2,520.0 сая төгрөг;
11. 2017 оны Сүхбаатар аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 368 дугаар шийдвэрээр Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас 5,966.7 сая төгрөг;
12. 2017 оны Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 1489 дүгээр магадлалаар Барилга, хот байгуулалтын яамнаас 1,284.4 сая төгрөг байна.

**АСУУЛТ 2. Ажлаас хууль бусаар халагдсан нийт хэдэн албан тушаалтанд нөхөн төлбөр олгох, тэдгээрээс хэд нь төрийн жинхэнэ албан хаагч, үйлчилгээний албан хаагч, албан тушаалтан байгаа талаар :**

ХАРИУЛТ: Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас олгох хохирлын нөхөн төлбөрт нийт 186 төлбөр авагчид 1,282.2 сая төгрөг олгохоор тусгасан. Үүнээс 182 иргэнд 1,281.9 сая төгрөгийг ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговорт, 4 шүүхийн шийдвэрээр 343.2 мянган төгрөгийг төлөгдөөгүй улсын тэмдэгтийн хураамжийн зардалд тусгасан.

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас олгох хохирлын нөхөн төлбөр авах 182 иргэнээс улс төрийн албан тушаалтан 5, төрийн жинхэнэ албан хаагч 143, төрийн үйлчилгээний албан хаагч 34 байна. мөн нийт 182 албан хаагчаас 23 нь сумын Засаг дарга, байгууллагын дарга, яам, газрын хэлтсийн дарга зэрэг удирдах албан тушаалтан байна.

**АСУУЛТ 3. Шүүхийн шийдвэрийн дагуу олгох дээрх мөнгөн дүнг буруутай этгээдүүдээр төлүүлэх асуудлаар судалгаа гаргасан эсэх, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнуудын судалгаа, хэнээр хэдэн төгрөг төсөвт буцаан төлүүлэх талаар мэдээлэл гаргасан эсэх;**

ХАРИУЛТ: Иргэний хуулийн 498.5-д зааснаар төрийн албан хаагч албан үүргээ зөрчиж гэм буруутай үйлдэл гаргасны улмаас бусдад учруулсан гэм хорын хохирол болон хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээж, мөрдөгч, прокурор, шүүгч буруутай эсэхээс үл хамааран түүнд учирсан хохирлыг төр хариуцан арилгах бөгөөд тухайн хохирлын нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.

Харин дээрх нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээс буцаан гаргуулах нэхэмжлэлийг эрүүгийн хэргийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.8.8 дахь заалтаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхэд гаргахаар зохицуулсан.

Захиргааны байгууллагын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, дотоод аудитын нэгжгүй байхгүй бол төрийн аудитын байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрийг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

Дээрх хуулийн зохицуулалтуудаас үзэхэд төрийн албан хаагчийн албан үүргээ зөрчиж гэм буруутай үйлдэл гаргасны улмаас улсад учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх үүргийг Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тухайн шийдвэрийг гаргасан захиргааны байгууллагын дээд шатны дотоод аудитын нэгж, эсвэл төрийн аудитын байгууллага, прокурорын байгууллага хүлээсэн байна.

Шүүхийн шийдвэрийн дагуу төр хариуцаж иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон хохирлын нөхөн төлбөрийн талаарх судалгаа, мэдээлэл, шүүхийн шийдвэрүүд Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд байгаа болно.

**АСУУЛГА 4. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны ерөнхий хуулийн 103.1, 103.2, 103.3 дахь хэсэгт захиргааны хууль бус шийдвэр гаргасны улмаас төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээс гаргуулах, энэ үйл ажиллагааг тухайн байгууллагын аудитын нэгж, ийм нэгж байхгүй бол төрийн аудитын байгууллага хэрэгжүүлэхээр тодорхой заасан байна. Хуулийн энэ зүйл заалт хэрхэн хэрэгжиж байгаа эсэх талаар, хууль бус шийдвэр гаргаж төрд хохирол учруулсан хэдэн албан тушаалтан хэдэн төгрөгийн хохирол өмнө нь нөхөн төлсөн, цаашид төсөвт суулгасан дээрх мөнгөн дүнг буруутай этгээдээр төлүүлэх эсэх талаар;**

**ХАРИУЛТ:** Шүүхийн шийдвэрээр эцэслэн шийдвэрлэгдсэн, нэг удаагийн шинж чанартай өр төлбөрийг барагдуулахтай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналтыг сайжруулах, төрийг шүүхэд төлөөлж байгаа этгээд тухайн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх бүх шатны шүүхэд хуульд заасан нөхцөл журмын дагуу оролцох, цаашид шүүхийн шийдвэртэй, нэг удаагийн шинж чанартай өр төлбөрийг бууруулах талаар дараах шат дараалсан арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагч ажлын хариуцлага алдсан, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрийн дагуу олгох нөхөн олговрын зохих хэсгийг тухай албан тушаалтнаар төлүүлдэг байх;

2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтны гаргасан буруутай шийдвэрийн хохирлыг улсын болон орон нутгийн төсвөөс бус тухайн албан тушаалтан эсхүл компаниар нь төлүүлдэг байх;

3. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шүүхэд төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэх байгууллагыг хуулиар тодорхой зааж, хохирол барагдуулах үйл ажиллагаанд оролцох чиг үүргийг нь тодорхой болгох зэрэг болно.

-----ooOoo-----